



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН  
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 01 дүгээр сарын 29 өдөр

Дугаар 06

Хэрлэн сум

Аймгийн Онцгой комиссын VI хуралдааныг 2020 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн 17:30 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 27 гишүүд оролцохоос 26 гишүүнтэй 96% ирцтэй хуралдав.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Эрүүл мэндийн яамнаас ирүүлсэн зөвлөмжийг Эрүүл мэндийн газрын дарга Ч.Оюунаа танилцуулах, зөвлөмжийн дагуу арга хэмжээг авах;
2. Тосон-Уул 19 дүгээр талбайгаас БНХАУ-ын иргэн 43 жолоочтой ачаа бүхий автомашинуудыг Сүхбаатар аймгийн Бичигт хилийн боомтоор гаргах тухай;


ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Бүсийн төв-Дорнод аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах, Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа нарт:

1. Эрүүл мэндийн яамнаас ирүүлсэн зөвлөмжийн дагуу Баян-Уул, Хөлөнбуйр, Баянтүмэн, Хэрлэн сумдад байгуулсан хяналт, шалгалтын 5 цэгийг буулгахыг,

Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн Х.Бат-Эрдэнэ, Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа нарт:

1. Тосон-Уул 19 дүгээр талбайгаас БНХАУ-ын иргэн 43 жолоочтой ачаа бүхий автомашинуудыг Сүхбаатар аймгийн Бичигт хилийн боомтоор гаргаж, 14 хоногийн хугацаанд буцаан Монгол улсын хилээр нэвтрүүлэхгүй байхыг;

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ, ОНЦГОЙ КОМИССЫН  
ОРЛОГЧ ДАРГА  Ч.ГАНБАТ

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА, ДЭД ХУРАНДАА  Д.БАТТУЛГА

